



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 11 дүгээр сарын 23
№43 (1291)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

549. Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн
албан тушаалд томилох тухай Дугаар 75 3315

550. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх
тухай Дугаар 83 3315

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

551. Журам шинэчлэн батлах тухай Дугаар 155 3316

552. Журам батлах тухай Дугаар 156 3322

553. Журам, бүтэц, орон тоо батлах тухай Дугаар 174 3329



444.0	ᠮᠠᠨᠤ / ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ / ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	444.0
444.0	ᠮᠠᠨᠤ / ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	444.0
445.0	ᠮᠠᠨᠤ / ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ / ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	445.0
445.0	ᠮᠠᠨᠤᠮᠠᠨᠤ Folo_ ᠠᠨ Jsa᠋ᠳᠤ ᠠᠨ Gᠢᠳᠦ ᠠᠨ Dooᠪᠠᠭᠢᠭᠢ		
445.0	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	445.0
445.0	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	445.0
445.0	ᠮᠠᠨᠤᠮᠠᠨᠤ Folo_ ᠠᠨ Yoo᠋ᠳᠢᠭᠢᠨᠠᠨᠢ I iia Jᠡᠷᠢᠯᠢ		
445.0	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	445.0
445.0	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	445.0
445.0	ᠮᠠᠨᠤᠮᠠᠨᠤ Folo_ ᠠᠨ Yoo᠋ᠳᠢᠭᠢᠨᠠᠨᠢ I iia Jᠡᠷᠢᠯᠢ		
445.0	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	445.0
445.0	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨᠠᠨᠢ	445.0



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2023 оны 06 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 75

Улаанбаатар
хот

Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 178 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1.Лувсанноровын Угтахбаярыг Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2.Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Лувсанноровын Угтахбаярыг Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2023 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 83

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 148 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн Зундуйн Энхцэцэгийг Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 04 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар 155

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, Агаарын тухай хуулийн 6.1.1¹, 6.1.2, 6.2, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8.1.2-т заасныг тус тус үндэслэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Уур амьсгалын Үндэсний хорооны ажиллах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Үндэсний хорооны ажиллах журмыг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Үндэсний хорооны дарга С.Амарсайханд даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай” Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 333 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Б.БАТ-ЭРДЭНЭ

Засгийн газрын 2023 оны 04 дүгээр
сарын 26-ны өдрийн 155 дугаар
тогтоолын хавсралт

УУР АМЬСГАЛЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Уур амьсгалын Үндэсний хороо (цаашид “Үндэсний хороо” гэх) нь Нэгдсэн Үндэстний Байгууллага (цаашид “НҮБ” гэх)-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцын Парисын хэлэлцээр, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцоор хүлээсэн үүрэг болон “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, цөлжилт, газрын доройтлыг бууруулах ажлын салбар дундын уялдааг хангах, зохицуулах үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

1.2.Үндэсний хороо нь үйл ажиллагаандаа Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Агаарын тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичиг болон журмыг удирдлага болгоно.

Хоёр.Үндэсний хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1.Үндэсний хорооны дарга нь Монгол Улсын Шадар сайд, орлогч дарга нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга байна. Үндэсний хорооны нарийн бичгийн дарга нь Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны уур амьсгалын асуудал эрхэлсэн нэгжийн дарга байна.

2.2.Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Үндэсний хорооны гишүүн нь хурлын үйл ажиллагаанд биечлэн оролцох бөгөөд хэлэлцэж буй асуудлаар санал гаргах, зөвлөмж өгөх болон Үндэсний хорооны тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд санал өгөх, хэрэгжилтийг хангах, шаардлагатай асуудлаар мэдээлэл хийх эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.3.Үндэсний хорооны хурлыг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулж, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцын Парисын хэлэлцээр, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэж байгаа ажлын явц болон холбогдох бусад асуудлыг хэлэлцэнэ.

2.4.Хурлын дэгийг Үндэсний хорооны хурлаар хэлэлцэн батална. Хурлыг Үндэсний хорооны дарга, түүнийг эзгүйд Үндэсний хорооны орлогч дарга удирдана.

2.5.Хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд Үндэсний хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Үндэсний хороо нь цөлжилт, газрын доройтлыг бууруулах асуудлаар тогтоол, тэмдэглэл, зөвлөмж гаргаж болно.

2.6.Үндэсний хорооноос гаргасан тогтоол, тэмдэглэл, зөвлөмжийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний биелэлт үр дүнг тогтоосон хугацаанд Үндэсний хороонд тайлагнана.

2.7.Үндэсний хороо нь дэд хороо болон мэргэжлийн зөвлөлтэй байж болно. Дэд хороо, мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батална.

2.8.Үндэсний хороо нь аймаг, нийслэлд салбар хороотой байх бөгөөд салбар хорооны дарга нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна. Салбар хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг салбар хорооны дарга батална.

2.9.Үндэсний хороо нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.10.Үндэсний хорооны нарийн бичгийн дарга нь хорооны хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдаанаас гарсан шийдвэрийг яам, холбогдох газруудад хүргүүлж, биелэлтэд хяналт тавих, Үндэсний хорооны өдөр тутмын ажлыг эрхэлнэ.

2.11.Үндэсний хорооны шийдвэрээр холбогдох яам, агентлаг, эрдэмтэн, судлаач, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг оролцуулан тодорхой асуудлаар төслийн баг, ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.

2.12.Үндэсний хорооны дэд хороод, мэргэжлийн зөвлөлийг үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа “Уур амьсгалын судалгаа хамтын ажиллагааны төв” ТӨҮГ, Ойн газар зэрэг байгууллагууд мэргэжлийн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллана.

Гурав.Хорооны эрх, үүрэг

3.1.Үндэсний хороо нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцын Парисын хэлэлцээр, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц,

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах эрхтэй:

3.1.1.уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах арга хэмжээтэй холбогдон гарсан хууль тогтоомж, Үндэсний хорооны шийдвэр, зөвлөмжийн биелэлтийг хянан шалгах, шаардлагатай мэдээ материалыг холбогдох байгууллага, иргэнээс гаргуулан авах, санал, дүгнэлт гаргах;

3.1.2.уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах талаар батлагдсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал, зөвлөмж гаргах;

3.1.3.уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуйн нэгж, холбогдох байгууллага иргэнийг урамшуулах, агро ойг хөгжүүлж, иргэдийн амьжиргааны тогтвортой эх үүсвэрийг бий болгох, иргэн, аж ахуйн нэгжид татварын болон татварын бус бодлогоор дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар санал, зөвлөмж гаргах;

3.1.4.байгалийн бүс, бүслүүр, байгаль, цаг уурын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх;

3.1.5.уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл, эрсдэлээс хамгаалах, түүнд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, цэвэр үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, хэрэглээний үр ашгийг сайжруулах, хог хаягдалгүй, эрчим хүчний хэмнэлттэй, уур амьсгалд нөлөөгүй арга хэрэгсэл, орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх талаар нийтлэг зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангах;

3.1.6.Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэрээр батлагдсан уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлээс хамгаалах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах чиглэлээр салбар дундын бодлого, зохицуулалтыг уялдуулах нэгдсэн төлөвлөлтийг гаргаж, бодлогын удирдамжаар хангах;

3.1.7.Үндэсний хорооны шийдвэр, зөвлөмжийг биелүүлээгүй байгууллага, албан тушаалтны талаар дээд шатны холбогдох байгууллага, удирдлагад нь албан ёсоор мэдэгдэж, хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах;

3.1.8.гадаад улс болон олон улсын байгууллагуудтай уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах асуудлаар

холбогдох журмын дагуу харилцах, мэдээлэл солилцох, судалгаа явуулах, төсөл хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах;

3.1.9.эрх хэмжээнийхээ асуудлаар олон улс, үндэсний чанартай хурал, зөвлөгөөн, семинар, ярилцлага зохион байгуулах, оролцох.

3.2.Үндэсний хороо нь дараах үүрэгтэй:

3.2.1.уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохицуулах;

3.2.2.уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах талаар гарсан төрийн бодлого шийдвэр, цөлжилттэй тэмцэх хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.3.уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах асуудлаар мэдээлэл сурталчилгаа хийх, сургалт, семинар зохион байгуулах;

3.2.4.уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачилгыг дэмжих, хамтран ажиллах;

3.2.5.уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах асуудлаар төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах;

3.2.6.уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах чиглэлээр холбогдох эрдэм шинжилгээний байгууллага, дотоод, гадаадын их, дээд сургууль, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;

3.2.7.уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал болон Үндэсний хорооноос явуулж буй үйл ажиллагаа үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр олон нийтэд сурталчлах.

Дөрөв.Бусад зүйл

4.1.Үндэсний хорооны үйл ажиллагааг бүтэн жилээр төлөвлөн хэрэгжилтийг хагас жил тутамд дүгнэн Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.2.Үндэсний хорооны үйл ажиллагааны зардлыг Үндэсний хороо хуралдаанаараа хэлэлцэн батлах бөгөөд эх үүсвэрийг нь жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.



4.3. Үндэсний хорооны үйлажиллагааны жилийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд Үндэсний хорооны гишүүдэд хүргүүлж танилцуулна.

4.4. Үндэсний хорооноос гарсан баримт бичгийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын архивд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүлээлгэж өгнө.

----o0o----



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 04 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар 156

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Музейн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Музейн сан хөмрөгийг гамшиг болон аюулын үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН



Засгийн газрын 2023 оны 04 дүгээр
сарын 26-ны өдрийн 156 дугаар
тогтоолын хавсралт

МУЗЕЙН САН ХӨМРӨГИЙГ ГАМШИГ БОЛОН АЮУЛЫН ҮЕД НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Музейн сан хөмрөгийг гамшиг болон аюулын үед түр хугацаагаар нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 24.1-д заасан хүч хэрэгслийг дайчлан өөр барилга байгууламж, эсхүл аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19.2-т заасан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг дагаж мөрдөнө.

1.3.Музейн сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

1.3.1.шуурхай байх;

1.3.2.нэгдмэл удирдлагатай байх;

1.3.3.хариуцлагатай байх;

1.3.4.дэвшилтэд техник, технологи, багаж хэрэгсэлд тулгуурлах;

1.3.5.ажилтан, албан хаагчдын тэгш оролцоог хангах.

1.4.Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн музей энэ журмыг дагаж мөрдөнө.

1.5.Гамшиг болон аюулын үед нүүлгэн шилжүүлснээс үүдэн гарах хохирлыг тооцоход Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20.3-т заасан “Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам”-ыг, гамшиг болон аюулын хор уршгийг арилгах үйл ажиллагаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20.4-т заасан “Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх журам”-ыг баримтлан зохион байгуулна.

Хоёр.Нэр томьёо

2.1.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“музейн сан хөмрөг” гэж Музейн тухай хуулийн 4.1.6-д заасныг;

2.1.2.“гамшиг” гэж Гамшгийн тухай хуулийн 4.1.1-д заасныг;

2.1.3.“аюул” гэж Гамшгийн тухай хуулийн 4.1.5-д заасныг.

Гурав.Нүүлгэн шилжүүлэх бэлэн байдал

3.1.Музейн сан хөмрөгийг гамшиг болон аюулын үед нүүлгэн шилжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөө (цаашид “бэлэн байдлын төлөвлөгөө” гэх) болон гамшиг болон аюулын үед ажиллах нарийвчилсан төлөвлөгөө (цаашид “нарийвчилсан төлөвлөгөө” гэх)-г музейн захирал харьяалах нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа онцгой байдлын байгууллагатай хамтран Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Музейн тухай хуулийг үндэслэн боловсруулж, музейг үүсгэн байгуулагчтай зөвшилцсөний үндсэн дээр батална.

3.2.Энэ журмын 3.1-д заасан бэлэн байдлын төлөвлөгөө болон нарийвчилсан төлөвлөгөө нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8.1-д заасан гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болгон хавсаргана.

3.3.Энэ журмын 3.1-д заасан төлөвлөгөөг 5 хувь үйлдэж, музейг үүсгэн байгуулагч, музейн захирал, харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, онцгой байдлын байгууллага болон музейн аюулгүй байдлыг хариуцсан нэгж, албан тушаалтан тус бүрд нэг хувийг хүлээлгэн өгч, төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцуулна.

3.4.Музейн захирал бэлэн байдлын төлөвлөгөө болон нарийвчилсан төлөвлөгөөг музейн албан хаагчдад танилцуулж, байгууллагын хэмжээнд болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран дадлага сургуулилт явуулж, чадавхжуулах арга хэмжээ авна.

3.5.Бэлэн байдлын төлөвлөгөө болон нарийвчилсан төлөвлөгөөг хэсэгчлэн болон бүтнээр нь хувилан олшруулахгүй, энэ журмын 3.3-т зааснаас бусад этгээдэд дамжуулахгүй, нийтийн хэрэгцээнд зориулан хэвлэн нийтлэхгүй байх үүрэг хүлээнэ.

3.6.Бэлэн байдлын төлөвлөгөө, нарийвчилсан төлөвлөгөө байгууллагын нууцад хамаарна.

Дөрөв.Бэлэн байдлын төлөвлөгөө

4.1.Музейн бэлэн байдлын төлөвлөгөө нь музейн сан хөмрөгийг гамшиг болон аюулын үед нүүлгэн шилжүүлэхэд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.24-т заасан “бэлэн байдал”-ыг хангахад чиглэсэн удирдлагын баримт бичиг байна.

4.2.Бэлэн байдлын төлөвлөгөөнд дараах мэдээллийг тусгана:

4.2.1.музейн үзмэр, цуглуулгын байршлын зураглал;

4.2.2.сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх аюулгүй байршил;

4.2.3.сан хөмрөгийг аюулгүй байршилд нүүлгэн шилжүүлэх маршрут;

4.2.4.үзмэр, цуглуулгыг ороож боох, хайрцаглах, зөөх зааварчилгаа;

4.2.5.үзмэр цуглуулгыг аюулгүй хэсэгт байршуулах зураглал;

4.2.6.үзмэр, цуглуулгыг нүүлгэн шилжүүлэхэд ашиглах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн байршил, тэдгээрийг ашиглах зааварчилгаа;

4.2.7.холбогдох бусад мэдээлэл.

4.3.Бэлэн байдлын төлөвлөгөөнд гамшиг болон аюулын шинж байдлыг харгалзан сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх аюулгүй орчны байршлыг 2-оос ихгүй хувилбартайгаар тусгаж болно.

4.4.Музейн захирал бэлэн байдлын төлөвлөгөөнд байнгын хяналт тавьж, холбогдох баримт бичиг, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг заасан байршилд байгаа эсэхийг тухай бүр шалгана.

4.5.Музейн захирал шаардлагатай бол бэлэн байдлын төлөвлөгөөнд харьяалах нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж зохих тодотгол хийж болно. Тодотголыг тухай бүр энэ журмын 3.3-т заасан этгээдэд хүргүүлнэ.

Тав.Нарийвчилсан төлөвлөгөө

5.1.Музейн нарийвчилсан төлөвлөгөө нь музейн сан хөмрөгийг гамшиг болон аюулын үед нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангахад чиглэсэн удирдлагын баримт бичиг байна.

5.2.Нарийвчилсан төлөвлөгөөнд дараах мэдээллийг тусгана:

5.2.1.гамшиг болон аюулын талаар мэдээлэх албан хаагч, хуулийн этгээдийн нэрс, холбогдох утасны дугаар, хаяг;

5.2.2.сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд оролцох албан хаагчдын нэрс, холбогдох утасны дугаар (2-оос доошгүй), гэрийн хаяг;

5.2.3.сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд оролцох албан хаагчдын цуглах байршил, үүрэг гүйцэтгэх замын зураг;

5.2.4.үзмэр, цуглуулгыг нүүлгэн шилжүүлэхэд ашиглах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг албан хаагчдад хуваарилсан жагсаалт;

5.2.5.сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд оролцох албан хаагчийг эзгүй үед түүнийг орлох албан хаагчийн нэрс, холбогдох утасны дугаар (2-оос доошгүй), гэрийн хаяг;

5.2.6.албан хаагчийн аюулгүй байршилд очих маршрутын зураглал (план);

5.2.7.нүүлгэн шилжүүлсэн үзмэр, цуглуулгад тавих хяналт.

5.3.Нарийвчилсан төлөвлөгөөнд албан хаагчдын музейн сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэхэд гүйцэтгэх үүрэг, хариуцах ажлыг давхцахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, тусгана.

Зургаа.Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

6.1.Музейн аюулгүй байдлын ажилтан, эсхүл харуул хамгаалалтын ажилтан гамшиг болон аюулын нөхцөл байдал тогтоогдмогц дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ:

6.1.1.музейн захирал болон харьяалах нутаг дэвсгэрийн Засаг дарга, онцгой байдлын болон цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

6.1.2.үйлчлүүлэгчдийг музейн танхимаас гаргах;

6.1.3.холбогдох бусад арга хэмжээг авах.

6.2.Нарийвчилсан төлөвлөгөөнд сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр томилогдсон албан хаагчид гамшиг

болон аюулын нөхцөл байдлын талаар мэдсэн даруйд товлосон газарт яаралтай цуглах үүрэгтэй.

6.3.Музейн албан хаагчид нарийвчилсан төлөвлөгөөнд заасны дагуу тус тусын хүлээсэн үүргийг гүйцэтгэнэ.

6.4.Гамшиг болон аюулын нөхцөл байдал хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахуйц хэмжээнд хүрсэн бол музейн албан хаагч нэн тэргүүнд гамшиг болон аюулын бүсийг орхин, аюулгүй байршилд очиж, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авна.

Долоо.Нүүлгэн шилжүүлсний дараах үйл ажиллагаа

7.1.Музейн захирал сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлсний дараа дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ:

7.1.1.аюулгүй орчинд байршуулсан үзмэр, цуглуулгад хяналтын тооллого хийх;

7.1.2.нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны улмаас үзмэр, цуглуулгад учирсан хохирлыг үнэлгээний байгууллагатай хамтран тооцож гаргах;

7.1.3.хяналтын тооллого болон хохирлын талаарх мэдээллийг үүсгэн байгуулагч, харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулах;

7.1.4.нүүлгэн шилжүүлсэн үзмэр, цуглуулгад харуул, хамгаалалтын болон хяналтын ажилтан томилж ажиллуулах.

7.2.Музейн захирал гамшиг болон аюулын улмаас үүссэн хохирлыг арилгах, нүүлгэн шилжүүлсэн үзмэр, цуглуулгыг анхны байрлалд буцаан байршуулах арга хэмжээг зохион байгуулна.

7.3.Гамшиг болон аюулын улмаас үүссэн хохирлыг арилгахад цаг хугацаа шаардлагатай болсон, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас нүүлгэн шилжүүлсэн үзмэр, цуглуулгыг анхны байршилд буцаан байршуулах боломжгүй болсон бол музейн захирал музейн үйл ажиллагаанд зохицуулалт хийж, музейн үйлчилгээг хязгаарлах, хаах арга хэмжээ авч болно.

7.4.Музейн захирал гамшиг болон аюулын талаар мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслэн музейн сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэхэд гарсан зардлыг буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ авна.



Найм.Бусад зүйл

8.1.Сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх, үйлчлүүлэгч, музейн ажилтныг гамшгаас хамгаалах болон гамшгийн үеийн үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх зэрэг гамшиг болон аюулын үеийн бэлэн байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүр төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

8.2.Энэ журмыг зөрчсөн бол Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.

----o0o----



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 174

Улаанбаатар
хот

Журам, бүтэц, орон тоо батлах тухай

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25.1.10, Монгол Улсын хилийн тухай хуулийн 35.1.6, 35.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын хилийн хяналт шалгалтыг сайжруулах, төрийн холбогдох байгууллагуудын мэдээлэл солилцох шуурхай байдлыг хангах, терроризмтой тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлэх болон иргэдийн аюулгүй байдал, хүний эрхийг хангах зорилгоор олон улсын стандартад нийцсэн, зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий “Зорчигчийн мэдээллийн төв”-ийг Засгийн газрын тохируулагч агентлаг-Хил хамгаалах ерөнхий газрын дэргэд байгуулсугай.

2.“Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Зорчигчийн мэдээллийн төвийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3.Зорчигчийн мэдээллийн төвийн үйл ажиллагааг энэ тогтоолын 2-т заасан журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн)-т даалгасугай.

4.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг 2023 оны батлагдсан төсвийн багцдаа багтаан хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн)-т тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Х.НЯМБААТАР



Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 09-ний өдрийн 174 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ОЛОН УЛСЫН НИСЛЭГ ҮЙЛДЭХ АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧЭЭС
ЗОРЧИГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ УРЬДЧИЛАН АВАХ, ХАРИЛЦАН
МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ТҮҮНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Монгол Улсын агаарын хилээр орох, гарах, дамжин өнгөрөх зорчигчийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хадгалах, хамгаалах, ашиглах, харилцан мэдээлэл солилцох, аюулгүй байдлыг хангах болон зорчигчийн мэдээллийн төвийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Энэ журмыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын хилийн тухай, Гаалийн тухай, Иргэний нисэхийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гүйцэтгэх ажлын тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон Нэгдсэн Үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөлийн 2178 (2014), 2396 (2017), 2482 (2019) тогтоол (цаашид “НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоол” гэх), олон улсын эрх зүйн хэм хэмжээг мөрдлөг болгоно.

1.3.“Зорчигчийн мэдээлэл” гэдэгт Зорчигчийн урьдчилсан мэдээлэл (цаашид “Advance Passenger Information” буюу “API” гэх) болон Зорчигчийн нэрийн бүртгэл (цаашид “Passenger Name Record” буюу “PNR” гэх)-ийн мэдээлэл хамаарна.

1.4.“Зорчигчийн мэдээллийн нэг цонх” (цаашид “Нэг цонх” гэх) гэдэгт Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 9 дүгээр хавсралтад заасны дагуу API болон PNR мэдээллийг нэг шугамаар дамжуулахыг ойлгоно.

1.5.“Зорчигчийн мэдээллийн төв” (цаашид “Төв” гэх) нь API болон PNR-ийн өгөгдлийг цуглуулах, хадгалах, боловсруулах, дүн шинжилгээ

хийх, ашиглах, харилцан солилцох, түүний аюулгүй байдлыг хангах, устгах үндсэн чиг үүрэгтэй.

1.6.Төв нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудсыг хэрэглэх бөгөөд өөрийн бэлгэ тэмдэгтэй байна.

Хоёр.Төвийн үйл ажиллагаа

2.1.Төвийн үйл ажиллагаа нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх бөгөөд төв нь чиг үүргээ хараат бус, бие даасан байдлаар хэрэгжүүлнэ.

2.2.Төв нь энэ журмын 1.5-д заасан үндсэн чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.2.1.хилийн боомтоор нэвтрэх зорчигчийн мэдээллийг олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс урьдчилан авч, мэдээллийн сан үүсгэх, бүртгэл хөтлөх;

2.2.2.зорчигчийн урьдчилсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

2.2.3.зорчигчийн мэдээллийг ашиглах;

2.2.4.зорчигчийн мэдээллийг хамгаалах, нууцлал, аюулгүй байдлыг хангах;

2.2.5.зорчигчийн мэдээллийг хадгалах, устгах;

2.2.6.Монгол Улсад, эсхүл олон улсад эрэн сурвалжлагдаж байгаа, зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлсэн зорчигчийн мэдээллийг эрх бүхий байгууллагад шуурхай хүргүүлэх;

2.2.7.террорист этгээд нэвтрэхгүй, орогнохгүй байх орчин нөхцөлийг бүрдүүлэх;

2.2.8.өөрт байгаа болон холбогдох бусад байгууллагуудаас авсан мэдээлэлд тулгуурлан стратегийн дүн шинжилгээг жил бүр хийх;

2.2.9.Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

2.2.10.олон улсын хэмжээнд ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох.



2.3.API болон PNR-ийн мэдээллийн систем, сүлжээг хамруулсан мэдээллийн дэд бүтэц нь кибер халдлагаас хамгаалагдсан байна.

2.4.Төвийн кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тагнуулын байгууллагаас хяналт тавьж, хамтран ажиллана.

2.5.Төв нь мэдээллийн дэд бүтцэд доголдол, саатал гарахаас урьдчилан сэргийлэх, доголдол, саатал гарсан тохиолдолд түүнийг арилгах арга хэмжээг шуурхай авч, 24/7 горимоор үйл ажиллагаагаа тасралтгүй явуулна.

2.6.Терроризмтой тэмцэх зөвлөл нь терроризм үл нутагших, террорист этгээд нэвтрэхгүй, орогнохгүй байх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулахад Төвд зөвлөмж, чиглэл өгч, хэрэгжилтэд нь хяналт тавина.

2.7.Төвийн даргыг Хил хамгаалах ерөнхий газрын дарга Терроризмтой тэмцэх зөвлөлтэй зөвшилцөн томилж, чөлөөлнө.

2.8.Төвийн дарга нь Төрийн албаны тухай хуулийн 22.1-д заасан нийтлэг болон мөн хуулийн 23.2.1-д заасан тусгай шаардлагыг хангасан байна.

2.9.Төвийн дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.9.1.төвийн үйл ажиллагааг захиргааны болон мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангах, албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавих, үр дүнг тооцох;

2.9.2.боловсруулалт хийсэн мэдээлэлд нэвтрэх, хяналт тавих;

2.9.3.агаарын тээвэрлэгчээс урьдчилан ирүүлсэн зорчигчийн мэдээллийн нууцлалыг хангуулах;

2.9.4.Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжийн хүрээнд харилцааны ажиллагаатай байгууллагыг мэдээллээр хангах;

2.9.5.төвийг хууль тогтоомжид заасан хүрээнд дотоод, гадаадын байгууллагад төлөөлөх, харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх;

2.9.6.төвийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тушаал гаргах, журам, аргачлал, зааврыг баталж мөрдүүлэх;

2.9.7.стратегийн, тактикийн, үйл ажиллагааны дүн шинжилгээ хийх аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж батлах;

2.9.8.төвийн албан хаагчийн гүйцэтгэх ажил үүргийн хуваарийг хууль тогтоомжид нийцүүлэн тогтоож, албан тушаалын тодорхойлолтыг батлуулах;

2.9.9.төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах;

2.9.10.тухайн жилд шаардагдах төсвийг боловсруулж, холбогдох дээд шатны байгууллагаар батлуулах;

2.9.11.төвийн бүтэц, орон тооны талаарх саналаа холбогдох дээд шатны байгууллагад уламжлах;

2.9.12.албан хаагчийг томилох, чөлөөлөх, хүний нөөцийг чадавхжуулах;

2.9.13.хуулиар хүлээсэн бусад.

2.10.Төв нь дарга, мэдээлэл хамгаалах ажилтан, хэлтсийн дарга, дүн шинжилгээний ахлах ажилтан, ажилтан, агаарын тээвэрлэгчтэй харилцах ахлах ажилтан, мэдээллийн аюулгүй байдлын ахлах ажилтан, сан хариуцсан ахлах ажилтан, хамтын ажиллагаа хариуцсан ахлах ажилтан, хууль, эрх зүй хариуцсан ахлах ажилтан, техникийн ажилтан, туслах ажилтнаас бүрдэх бөгөөд тэдгээрийн албан тушаалын зэрэглэлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.11.Мэдээлэл хамгаалах ажилтан API болон PNR-ийн өгөгдлийн боловсруулалтад хяналт тавих болон хуульд заасан бусад арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.12.Мэдээлэл хамгаалах ажилтныг чиг үүргээ үр дүнтэй, хараат бус байдлаар бие даан гүйцэтгэх нөхцөлөөр хангана.

2.13.Мэдээлэл хамгаалах ажилтан боловсруулалт хийгдсэн бүх өгөгдөлд нэвтрэх эрхтэй бөгөөд өгөгдлийн боловсруулалт хууль ёсны дагуу хийгдээгүй гэж үзвэл, уг асуудлыг хяналт тавих эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

2.14.Мэдээлэл хамгаалах ажилтны хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 24.1-д заасны дагуу Хүний эрхийн үндэсний комисс, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон болон онц чухал мэдээллийн дэд бүтцийн кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 13.1-д заасны дагуу тагнуулын байгууллага тус тус хяналт тавина.

2.15.Дүн шинжилгээний ахлах ажилтан, ажилтан нь үйл ажиллагааны, тактикийн, стратегийн түвшинд мэдээллийн боловсруулалтыг хийж ажиллана.

2.16.Агаарын тээвэрлэгчтэй харилцах ахлах ажилтан нь тээвэрлэгчид (агаар, ус, хуурай газар)-тэй хэрэгжиж байгаа тээвэрлэлтийн талаарх тухайлсан ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, холбох үүргийг хэрэгжүүлнэ.

2.17.Мэдээллийн аюулгүй байдлын ахлах ажилтан нь цахим хэлбэрээр боловсруулсан мэдээллийн аюулгүй байдал, сүлжээний аюулгүй байдал, нууцлал, хяналтыг хариуцаж, үйл ажиллагааг хэвийн, найдвартай явуулах ажлыг зохион байгуулна.

2.18.Сан хариуцсан ахлах ажилтан нь мэдээллийн систем, өгөгдлийн сан, программ хангамжийг хариуцан ажиллана.

2.19.Техникийн ажилтан нь техник, тоног төхөөрөмж, дэд бүтэц, сүлжээний бүрэн, бүтэн байдлыг тасралтгүй хангаж ажиллана.

2.20.Хамтын ажиллагаа хариуцсан ахлах ажилтан нь гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллага, олон улсын байгууллага болон эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд харилцана.

2.21.Хууль, эрх зүй хариуцсан ахлах ажилтан нь төвийн үйл ажиллагаа Монгол Улсын олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

2.22.Терроризмын гэмт хэрэг, хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах, хилийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг шалгах зорилгоор төвийн бүрэлдэхүүнд дараах эрх бүхий байгууллага (цаашид “эрх бүхий байгууллага” гэх)-ын албан хаагчийг холбогдох хууль, журмын дагуу сэлгэн ажиллуулна:

2.22.1.Тагнуулын ерөнхий газар;

2.22.2.Хил хамгаалах ерөнхий газар;

2.22.3.Цагдаагийн ерөнхий газар;

2.22.4.Гадаадын иргэн, харьяатын газар;

2.22.5.Гаалийн ерөнхий газар.

2.23.Эрх бүхий байгууллага нь API болон PNR-ийн өгөгдөл болон түүний боловсруулалтын санд нэвтрэх эрхтэй бөгөөд өгөгдөлд хяналт тавьж, түүнийг хангалттай түвшинд хамгаалагдсан байх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

2.24.Эрх бүхий байгууллага мэдээллийн автомат боловсруулалтын үр дүнд үндэслэн хүний эрх, эрх чөлөөнд халдах, эсхүл ноцтойгоор нөлөөлөхүйц аливаа шийдвэр гаргахгүй.

2.25.Зорчигчийн мэдээллийг албан ажлынхаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

2.26.НҮБ-ын “Удирдлага, худалдаа, тээврийн цахим өгөгдөл солилцооны дүрэм”-ийн (UN/EDIFACT) Зорчигчийн жагсаалтын мэдээ (PAXLST) нь зорчигчийн манифестийн цахим дамжуулалтыг зохицуулах зорилгоор тусгайлан боловсруулсан стандарт цахим мэдээ байна.

2.27.Зорчигчийн мэдээлэл нь “НҮБ-ын Удирдлага, худалдаа, тээврийн цахим өгөгдлийн солилцооны дүрэм”-ийн (UN/EDIFACT) Зорчигчийн жагсаалтын мэдээ (PAXLST) илгээх техникийн тодорхойлолттой нийцсэн байна.

2.28.Төвийн мэдээллийн дэд бүтэц нь хүний үндсэн эрх, эрх чөлөө, олон улсын стандарт шаардлагыг хангасан байна.

2.29.Төв нь НҮБ-ын Терроризмтой тэмцэх хорооны гүйцэтгэх алба (UNCTED) (цаашид “Хороо” гэх), Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC), Терроризмтой тэмцэх алба (UNOCT), Мэдээлэл, харилцаа холбооны технологийн алба (OICT), Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO), Олон улсын агаарын тээврийн холбоо (IATA), Дэлхийн гаалийн байгууллага (WCO), Интерполын үндэсний товчоо (INTERPOL), Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (IOM) зэрэг олон улсын байгууллагатай тэдгээрийн стандарт, зөвлөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

2.30.Төв нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолын дагуу гишүүн улсууд өөрийн газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа агаарын тээвэрлэгчээс иргэний агаарын хөлөг, түүний зорчигчийн тухайн газар



нутгаас хөөрсөн, тухайн газар нутагт нэвтрэхийг оролдсон, дамжин өнгөрснийг тогтоох зорилгоор ирүүлсэн API мэдээллийг Монгол Улсын эрх бүхий байгууллагад өгөх, эсхүл гишүүн улсуудад Монгол Улсын газар нутгаас энэ төрлийн аливаа хөөрөлт, нэвтрэх оролдлого хийсэн, дамжин өнгөрсөн хувь хүний талаар Хороонд мэдээлнэ.

2.31.Монгол Улсын олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн дагуу зорчигчийн мэдээллийг тухайн зорчигчийн оршин суугаа болон харьяалах улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хуваалцана.

2.32.Төв нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолын Хорооноос тодорхойлсон хувь хүн, террорист этгээд агаарын хөлгөөр Монгол Улсын газар нутгаас хөөрсөн, зорчихыг оролдсон, Монгол Улсын нутагт дэвсгэрт нэвтэрсэн, дамжин өнгөрсөн талаар болон зорчигчийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, дүн шинжилгээ хийх зорилгоор агаарын тээвэрлэгчээс эрх бүхий байгууллагад Монгол Улсын олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн дагуу API мэдээллийг гаргаж өгөхийг шаардана.

Гурав.Зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, мэдээллийн сан бүрдүүлэх

3.1.Агаарын тээвэрлэгч нь өөрийн мэдээллийн санд цуглуулсан API болон PNR мэдээллийн өгөгдөлд хамаарах хэсгийг буюу мэдээллийн зөрүүг Төвийн мэдээллийн санд албан бус журмаар нислэгийн хуваарьт хөөрөх цагаас 48 цагийн өмнө нэг удаа, албан журмаар 24 цагийн өмнө нэг удаа, нисэх бодит цагт, эсхүл техникийн хязгаарлалттай үед буюу нислэгийн хөөрөх цагаас 15 минутын өмнө зөвшөөрөх хугацаанд багтаан шилжүүлнэ.

3.2.Агаарын тээвэрлэгчээс нэг цонх руу дамжуулах мэдээллийн өгөгдөл нь үнэн зөв, бүрэн гүйцэд байна.

3.3.Техникийн доголдол гарсан тохиолдолд агаарын тээвэрлэгч нь өгөгдлийн аюулгүй байдлыг зохих түвшинд хангасны үндсэн дээр бусад зохистой арга хэрэгслийг ашиглан цахим хэлбэрээр мэдээллийг дамжуулна.

3.4.Энэхүү журмын 1.1-д заасан зорилготой холбоотой тодорхой аюул заналын үед хариу арга хэмжээ авах зорилгоор өгөгдөлд хандах шаардлагатай тохиолдолд журмын 3.1-д заасан хуваарийг харгалзахгүйгээр PNR өгөгдлийг дамжуулахыг агаарын тээвэрлэгчээс нэн даруй шаардан авч болно.



3.5. API-ийн мэдээллийн өгөгдөл нь дараах мэдээллээс бүрдэнэ:

3.5.1. олон улсын агаарын тээвэрлэгчийн код болон нислэгийн дугаар;

3.5.2. агаарын хөлгийн хөөрөх улсын орон нутгийн цагаар тооцсон нислэгийн хөөрөх хуваарьт огноо, цаг;

3.5.3. агаарын хөлгийн буух улсын орон нутгийн цагаар тооцсон буух хуваарьт огноо, цаг;

3.5.4. агаарын хөлгийн хөөрсөн хамгийн сүүлийн улс, газар нутаг, газардсан боомт, эсхүл агаарын хөлгийн анхлан хөөрсөн улс, газар нутаг, боомт руу буцахаар хамгийн сүүлд хөөрсөн гадаадын улс, газардсан боомт;

3.5.5. агаарын хөлгийн анхлан буух улс, газар нутаг, боомт, эсхүл агаарын хөлгийн хөөрсөн хамгийн сүүлийн улс, газар нутаг, зогссон боомтоос очих улс дахь газар нутаг, боомт;

3.5.6. улс доторх агаарын хөлгийн дараагийн буух газар, газардах боомт;

3.5.7. агаарын хөлгийн нийт зорчигчийн тоо;

3.5.8. зорчигчийн гадаад паспорт, эсхүл түүнийг орлох бусад баримт бичгийн мэдээлэл.

3.6. PNR-ийн мэдээллийн өгөгдөл дараах мэдээллээс бүрдэнэ:

3.6.1. зорчигчийн албан ёсны баримт бичгийн машинаар уншигдах хэсэгт байгаа үндсэн өгөгдлийн бүрэлдэхүүн хэсэг. Үүнд:

3.6.1.а. зорчигчийн гадаад паспорт, эсхүл түүнийг орлох бусад баримт бичгийн дугаар;

3.6.1.б. зорчигчийн гадаад паспорт, эсхүл түүнийг орлох бусад баримт бичгийг олгосон улс, эрх бүхий байгууллага;

3.6.1.в. зорчигчийн гадаад паспортын төрөл;

3.6.1.г. зорчигчийн гадаад паспортын дуусах хугацаа;

3.6.1.д. гадаад паспорт эзэмшигчийн овог, нэр;

3.6.1.ж.гадаад паспорт эзэмшигчийн иргэний харьяалал;

3.6.1.з.гадаад паспорт эзэмшигчийн төрсөн огноо;

3.6.1.е.гадаад паспорт эзэмшигчийн хүйс.

3.6.2.PNR дэх дэлгэрэнгүй мэдээлэл:

3.6.2.а.зорчигчийн овог, нэр;

3.6.2.б.цол хэргэм;

3.6.2.в.зорчигчийн нэрсийн бүртгэл дэх бусад нэр.

3.6.3.Монгол Улсад нэвтрэх визийн мэдээлэл, Монгол Улсад нэвтрэх визийн зөвшөөрлийн мэдээлэл;

3.6.4.дэлгэрэнгүй хаягийн мэдээлэл:

3.6.4.а.холбоо барих хаяг;

3.6.4.б.баримт бичиг илгээх хаяг;

3.6.4.в.яаралтай холбоо барих хаяг;

3.6.4.г.цахим шуудангийн хаяг;

3.6.4.д.шуудангийн хаяг;

3.6.4.е.гэрийн хаяг.

3.6.5.холбоо барих утасны дугаар;

3.6.6.байнгын нисэгчийн (frequent flyer) мэдээлэл, дансны мэдээлэл, түвшин;

3.6.7.PNR-ийн код, файлын дугаар, захиалгын лавлах болон хяналтын дугаар;

3.6.8.PNR-д бүртгэгдсэн зорчигчдын код;

3.6.9.PNR үүсгэсэн, захиалга өгсөн, ирэх болон буцах зэрэг огноотой холбоотой бүх мэдээлэл;



3.6.10.нислэгийн тийзтэй холбоотой дараах мэдээлэл:

3.6.10.а.тийз олгосон/худалдаж авсан;

3.6.10.б.суудлын ангилал;

3.6.10.в.тийз олгосон хот;

3.6.10.г.тийзийн дугаар;

3.6.10.д.тийзийн автомат үнийн санал (ATF Q)-ын хэсэг.

3.6.11.PNR-ийн хуваагдмал мэдээлэл;

3.6.12.PNR дэх аяллын бүх чиглэл буюу маршрут;

3.6.13.төлбөрийн хэлбэрийн талаарх (TX-FOP) мэдээлэл;

3.6.14.бүртгэлтэй холбоотой бүх мэдээлэл;

3.6.15.суудлын тухай бүх мэдээлэл;

3.6.16.ачаа тээшний талаарх бүх мэдээлэл;

3.6.17.аялал жуулчлалын байгууллагын буюу компанийн талаарх мэдээлэл;

3.6.18.хүлээн авсан мэдээлэл буюу захиалга өгсөн хүний нэр;

3.6.19.эрт нисэх хүсэлтэй холбоотой мэдээлэл;

3.6.20.ирэх боломжгүй болсонтой холбоотой мэдээлэл;

3.6.21.ерөнхий тайлбар хэсэг дэх бүх мэдээлэл;

3.6.22.бусад үйлчилгээний тухай мэдээлэл (OSI), тусгай үйлчилгээний хүсэлт (SSR), аюулгүй байдлын талаарх мэдээллийн (SSI) тайлбар/түүх үнэгүй бичвэр буюу текст/кодын хэсэг;

3.6.23.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу урьдчилан авах шаардлагатай мэдээлэл.

3.7. Агаарын тээврийн систем дэх нэмэлт өгөгдөл нь дараах мэдээллийг агуулна:

3.7.1. зорчигчийн суудлын мэдээлэл;

3.7.2. зорчигчийн ачаа тээшний шошгын дугаар болон нийт жингийн мэдээлэл;

3.7.3. зорчигч, агаарын хөлгийн баг, дамжин өнгөрөх үе;

3.7.4. анхны буух газар/боомт (Аялагчийн гадаад аялал эхэлсэн газар, боомт);

3.7.5. зорчигчийн хилийн хяналтын байгууллагаар шалгуулсан газар/боомт;

3.7.6. зорчигчийн дамжин өнгөрөх гадаад дахь газар/боомт;

3.7.7. зорчигчийн нэрийн бүртгэлийн дугаар болон содон таних тэмдэг;

3.7.8. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24.3-т заасны дагуу гадаадын иргэнд олгох бүртгэлийн дугаар.

Дөрөв. Зорчигчийн мэдээллийг боловсруулах

4.1. Энэ журмын дагуу цуглуулсан PNR-ийн мэдээлэлд олон улсын стандартын дагуу гагцхүү терроризмын гэмт хэрэг, хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах, улсын хилээр нэвтрэх зорчигчдод хяналт тавих, хилийн аюулгүй байдлыг хангах зорилгоор боловсруулалт хийгдэнэ.

4.2. PNR-ийн мэдээллийн өгөгдлийг дараах зорилгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгахад ашиглаж болно:

4.2.1. үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хангах, сайжруулах;

4.2.2. зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэг, терроризмын гэмт хэрэг, террорист үйлдэл, түүнтэй холбоотой гэмт хэрэг болон бусад хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байгаа, эсхүл дээрх гэмт хэрэгт шалгагдаж байгаа этгээд оргон зайлахаас урьдчилан сэргийлэх;

4.2.3. зорчигчид болон олон нийтийн нэн чухал ашиг сонирхол, түүний дотор эрүүл мэндийг хамгаалах;

4.2.4. нисэх буудал дахь хилийн хяналтын ажиллагааг сайжруулах;

4.2.5. хууль ёсны зорчигчдын урсгалд дэмжлэг үзүүлэх, харгалзан хамгаалах;

4.2.6. нисэхийн аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

4.3. Энэ журмын 4.1-д зааснаас бусад зорилгоор API-ийн өгөгдөлд боловсруулалт хийж болно.

4.4. Олон улсын нислэгээр зорчиж байгаа зорчигчдын дэлгэрэнгүй мэдээллийг террорист этгээд, гэмт хэрэгтний тухай олон улсын мэдээллийн сангаас урьдчилан авах, мэдээлэлд боловсруулалт, дүн шинжилгээг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан аргачлалын дагуу дүн шинжилгээний ажилтан хийнэ.

4.5. PNR-ийн өгөгдөлд энэ журмаас өөр зорилгоор, эсхүл тусгайлан зорьсон зорилгодоо нийцээгүй боловсруулалт хийхийг хориглоно.

4.6. Төвийн API болон PNR-ийн өгөгдөлд боловсруулалт хийх үйл ажиллагаа нь дараах арга хэмжээнээс бүрдэнэ:

4.6.1. энэ журмын 4.2.2-т заасан терроризмын гэмт хэрэг, хүнд гэмт хэрэгт холбогдсон байж болзошгүй этгээдийг олж тогтоохын тулд үнэлгээнд ашигладаг шалгуур үзүүлэлтүүд (PNR-ийн өгөгдлийн автомат боловсруулалтад ашиглагддаг шалгуур үзүүлэлтүүд)-ийг шинэчлэх, эсхүл шинээр бий болгох зорилгоор API болон PNR-ийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

4.6.2. эрх бүхий байгууллага хуулийн дагуу арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг баталгаажуулах зорилгоор API болон PNR-ийн өгөгдлийн автомат боловсруулалт хийгдсэний үр дүнд гарсан аливаа тохирсон илэрцийг автомат бус аргаар нэг бүрчлэн шалгах.

4.7. Бусдыг хууль бусаар ялгаварлан гадуурхах, ялгаварлан гадуурхах нөхцөлийг бүрдүүлэхгүй байхын тулд PNR-ийн өгөгдлийг автоматаар боловсруулах ажиллагаа нь бодит үндэслэл бүхий шалгуурт тулгуурлана. PNR-ийн өгөгдлийн автомат боловсруулалтад үндэслэн бусдад ноцтой сөрөг нөлөө үзүүлэх, бусдын хууль ёсны ашиг сонирхол, эрх, эрх чөлөөг хөндсөн шийдвэр гаргаж болохгүй.



4.8. PNR-ийн өгөгдлийн автомат боловсруулалт нь хүнийг хууль бусаар ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байх, эрсдэл байгаа эсэхийг илэрхий харуулсан бодитой, үнэн зөв, найдвартай шалгуурт үндэслэгдсэн байна. PNR-ийн өгөгдлийн автомат боловсруулалт нь ялгаварлан гадуурхсан шинжтэй байж болохгүй.

4.9. Өгөгдлийн боловсруулалт хийхэд API болон PNR-тай холбоотой өгөгдлийг цуглуулах, бүртгэх, эвлүүлэх, хадгалах, өөрчлөх, хувиргах, буцаан дуудах, сэргээх, тооцох, ашиглах, дамжуулах, түгээх, өөр хэлбэрээр ашиглах боломжтой болгох, бусад хэлбэрээр ашиглах, зэрэгцүүлэх, хамтатгах, нийлүүлэх, арилгах, устгах зэрэг үйлдлийг бүхэлд нь хамруулна.

4.10. Төв нь зорчигч тасалбар худалдан авсан, эсхүл нислэгийн бүртгэл хийлгэсэн даруйд тухайн зорчигчийн мэдээллийг төрийн мэдээллийн сан болон интерполоор эрэн сурвалжилж байгаа этгээдийн жагсаалт, нисэж болохгүй анхаарах зорчигчдын жагсаалт (Watch List), хар жагсаалт (Black List), визийн болон аяллын баримт бичгийн мэдээллийн сантай тулгаж, эрсдэлийн дүн шинжилгээ хийснээр үр дүнг эрх бүхий байгууллагуудад шуурхай мэдэгдэнэ.

4.11. Дүн шинжилгээний ажилтан нь төвийн мэдээллийн дэд бүтцэд нэвтрэн ажиллах бөгөөд өөрийн болон бусад байгууллагын мэдээллийг боловсруулна. Ангилсан мэдээллийн сан тагнуулын үйл ажиллагаатай холбоотой тохиолдолд тагнуулын ажилтан өөрсдийн тааруулсан тохируулгыг шалгаж, бусад тохиолдолд цагдаагийн ажилтан өөрсдийн тааруулсан тохируулгыг шалгах байдлаар ажиллана.

Тав.Зорчигчийн мэдээллийг ашиглах, солилцох

5.1. Терроризмын гэмт хэрэг, хүнд гэмт хэрэгтнийг илрүүлэх, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2482 (2019) дугаар тогтоолын дагуу гишүүн улсууд API мэдээлэл цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх, Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ИКАО)-ын хэм хэмжээ, стандартыг хөгжүүлэх, PNR мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх хүрээнд API, PNR-ийн өгөгдлийг ашиглана. Эрх бүхий байгууллагууд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зохион байгуулалттай гэмт бүлэглэл, түүний гишүүн, тэдгээртэй холбоотой хувь хүн, террорист этгээдийг тогтоох, илрүүлэх, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог тогтоох, хөдөлгөөнийг таслан зогсоох, терроризмын гэмт хэрэг, үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг, хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор санг ашиглана.

5.2.Тухайн нислэгээс дамжуулахыг шаардах PNR-ийн өгөгдлийн тоог хамгийн боломжит доод хэмжээнд байлгана.

5.3.Агаарын тээвэрлэгч PNR-ийн өгөгдлийг дараах хугацаанд нэг цонх руу дамжуулна:

5.3.1.Агаарын хөлөг хөөрөх хуваарьт цагаас 48 цагийн өмнө нэг удаа;

5.3.2.Хөөрөх бодит цагт, эсхүл техникийн хязгаарлалттай тохиолдолд 15 минутын зайтай хөлгийн хөөрөх хуваарьт хугацаанд нэг удаа.

5.4.Хэрэв PNR-ийн өгөгдлийг анхлан дамжуулсны дараа нислэгүүд цуцлагдвал агаарын хөлөг хөөрөх бодит болон агаарын хөлгийн хөөрөх хуваарьт цагт өгөгдөл дамжуулалт дахин хийгдэхгүй.

5.5.API-ийн өгөгдлийг бүртгэл хийгдэх явцад цуглуулах ба үүний дараа нислэгийн тохируулга хийгдэх үед, эсхүл нислэг үйлдэгдсэний дараа нэг манифест буюу хуудас мэдээ хэлбэрээр нэн даруй дамжуулна.

5.6.Агаарын хөлгийн багийн гишүүдийн хувьд зорчигчдыг нислэг үйлдэхээр бэлтгэж байгаа агаарын хөлөгт суусан болон агаарын хөлөгт суух, эсхүл буух боломжгүй болсон үед API-ийн агаарын хөлгийн багийн гишүүдэд зориулсан манифест олгоно.

5.7.Агаарын тээвэрлэгч API-ийн өгөгдлийг дараах хугацаанд нэг цонх руу дамжуулна:

5.7.1.нислэгийн хуваарьт цагийн дагуу агаарын хөлөг хөөрөхөөс 30 минутын өмнө нэг удаа;

5.7.2.зорчигчдыг нислэг үйлдэхээр бэлтгэж байгаа агаарын хөлөгт суусан болон суух, буух боломжгүй болж, нислэг хаагдсаны дараа нэн даруй нэг удаа.

5.8.Төв нь хууль хяналтын байгууллагатай байгуулсан гэрээ, санамж бичгийн хүрээнд мэдээллийн сан болон бусад холбогдох баримтын талаар мэдээлэл солилцоно.

5.9.Төв нь энэ журмын 2.2.1-д заасан зорчигчийн мэдээллийн санг бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.9.1.Нэг цонхноос API болон PNR-ийн өгөгдлийг хүлээн авах, хадгалах, боловсруулалт хийх, тэдгээрийн өгөгдөл, эсхүл өгөгдөл боловсруулалтын үр дүнг 2.22-т заасан эрх бүхий байгууллагад дамжуулах;

5.9.2.API болон PNR-ийн өгөгдөл, өгөгдөл боловсруулалтын үр дүнг гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллага болон интерполын үндэсний товчоотой хуваалцах, дамжуулах;

5.9.3.API мэдээллийг дотоодын холбогдох мэдээллийн сан болон интерполоор эрэн сурвалжилж байгаа этгээдийн жагсаалт, нисэж болохгүй анхаарах зорчигчдын жагсаалт (Watch List), хар жагсаалт (Black List), бусад олон улсын эрх бүхий, бүс нутгийн байгууллага, гадаад улсын хоригийн жагсаалттай харьцуулж шалгах;

5.9.4.API мэдээллийг төрийн мэдээллийн сан болон интерполоор эрэн сурвалжилж байгаа этгээдийн жагсаалт, нисэж болохгүй анхаарах зорчигчдын жагсаалт (Watch List), хар жагсаалт (Black List), визийн болон аяллын баримт бичгийн мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэлтэй тохирсон тохиолдолд энэ журмын 2.15-д заасан дүн шинжилгээний ажилтан нэн даруй дараагийн шатны арга хэмжээ авах талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэх.

Зургаа.Мэдээллийг хадгалах, устгах

6.1.Төв нь агаарын тээвэрлэгчийн дамжуулсан зорчигчийн мэдээллийн өгөгдлийг цуглуулснаас хойш 2 жилээс илүүгүй хугацаанд багтаан тухайн хүнийг тодорхойлох боломжгүй төлөв (зиплэх)-т хадгална. PNR-ийн өгөгдөл хадгалах нийт хугацаа 5 жилээс хэтрэхгүй бөгөөд энэ хугацаа өнгөрсний дараа PNR өгөгдлийг мэдээллийн сангаас устгана.

6.2.Дээрх өгөгдөл хадгалах хугацаа дууссаны дараа терроризмын гэмт хэрэг, хүнд гэмт хэрэг, эсхүл хилийн аюулгүй байдалтай холбоотой гэж тодорхойлсон тодорхой хэрэг, аюул занал, эрсдэлтэй холбогдуулан ашиглахаас бусад тохиолдолд API-ийн өгөгдлийг хадгалагдаж байгаа мэдээллийн сангаас устгана. PNR-ийн өгөгдлийг хувийн шинж чанар агуулаагүй, зорчигчийг шууд таних боломжгүй болгоно.

6.3.Шаардлагатай тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд PNR-ийн өгөгдлийг устгах хугацааг сунгаж болно.

Долоо.Хувь хүний мэдээллийг хамгаалах

7.1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 8.1-д заасны дагуу агаарын тээвэрлэгч, нислэгийн тийз борлуулагч нь хуульд зааснаас

бусад тохиолдолд мэдээллийг цуглуулах, ашиглахдаа мэдээллийн эзнээс зөвшөөрөл авна.

7.2.Эрх бүхий байгууллагууд зорчигчийн мэдээллийг хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалж, зөвхөн террорист үйлдэл, түүнтэй холбогдох шилжилт хөдөлгөөнөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах зорилгыг хангах хүрээнд ашиглана.

7.3.Эрх бүхий байгууллагууд API болон PNR-ийн өгөгдөлд зохих ёсоор хяналт тавьж, эдгээр өгөгдөл хангалттай түвшинд хамгаалагдсан байх нөхцөлийг бүрдүүлнэ.

7.4.Эрх бүхий байгууллагууд автомат мэдээлэл боловсруулалтын үр дүнг үндэслэн хувь хүний эрх зүйн байдлыг дордуулсан шийдвэр гаргаж болохгүй. Энэхүү шийдвэр нь хүний арьс өнгө, үндэс угсаа, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, итгэл үнэмшил, нийгмийн гарал үүсэл, эрүүл мэнд, бэлгийн чиг хандлага зэрэгт үндэслэж болохгүй.

7.5.Арьс өнгө, үндэс угсаа, үзэл бодол, шашин шүтлэг, итгэл үнэмшил, гишүүнчлэл, эрүүл мэнд, хүйс, бэлгийн чиг хандлагын мэдээлэлд боловсруулалт хийхийг хориглоно.

7.6.Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 9.2-т зааснаас бусад тохиолдолд хувийн эмзэг мэдээлэл агуулсан PNR-ийн өгөгдлийг олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс хүлээн авбал боловсруулалт хийхгүй устгана.

7.7.Хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс онцгой буюу нэн шаардлагатай тохиолдолд иргэнд аливаа хохирол учруулахгүйгээр PNR-ийн өгөгдөлд боловсруулалт хийхийг зөвшөөрч болно.

7.8.Агаарын тээвэрлэгч энэ журамд заасан зорилгоор хувь хүний өгөгдлийг цуглуулж, боловсруулах, дамжуулах талаар зорчигчид мэдэгдэнэ. Зорчигчид өгсөн мэдээлэлд хувийн өгөгдлийг хамгаалахтай холбоотой эрхийн талаар мөн дурдсан байна.

Найм.Хамгаалалт, хяналт шалгалт

8.1.Зорчигчийн мэдээллийн өгөгдөлд зөвшөөрөлгүй нэвтрэх, задруулах, урвуулан ашиглах тохиолдолд хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.



8.2. Эрх бүхий байгууллага хяналт тавихдаа дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

8.2.1. хувь хүний гаргасан гомдлын дагуу хянан шийдвэрлэх, гомдлыг шийдвэрлэх ажлын явц, үр дүнгийн талаар хуульд заасан хугацаанд гомдол гаргагчид эргэн мэдээлэх;

8.2.2. холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн санаачилгаар, эсхүл гаргасан гомдлын үндсэн дээр өгөгдөл боловсруулалт хууль ёсны дагуу хийгдсэн эсэхийг баталгаажуулж, мөрдөн шалгах, хяналт шалгалт, аудит хийх.

8.3. Мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэлтэй эрх бүхий байгууллага зорчигчийн мэдээллийг хүлээн авсны дараа хууль тогтоомжийн дагуу нарийвчилсан шалгалт хийж, холбогдох шийдвэрийг гаргана.

8.4. Төв нь Төвийн даргын баталсан онцгой нөхцөлийн үед ажиллах төлөвлөгөөтэй байх бөгөөд уг төлөвлөгөөнд Төвд ажиллах эрх бүхий байгууллагуудын саналыг тусгасан байна.

Ес. Бусад

9.1. Төрийн болон албаны нууц, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

9.2. Агаарын тээвэрлэгч нь зорчигчийн урьдчилсан мэдээллийг үнэн зөв цуглуулж, дамжуулсан хэдий ч зорчигчийн мэдээлэлд техникийн доголдлоос шалтгаалан алдаа гарсан бол хариуцлага хүлээхгүй.

9.3. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.4. Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---



Журмын хавсралт

**PNR-ИЙН УДИРДАМЖИД ТУСГАСАН PNR-ИЙН ӨГӨГДЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН ЖАГСААЛТ**

PNR дэх нэрийн дэлгэрэнгүй мэдээлэл	Зорчигчийн нэр, овог, өөрийн нэр, цол хэргэм, PNR дээрх бусад нэр
Хаягийн дэлгэрэнгүй мэдээлэл	Холбоо барих хаяг, баримт бичиг илгээх хаяг, яаралтай тусламж шаардлагатай үед холбоо барих хаяг, цахим шуудангийн хаяг, шуудангийн хаяг, гэрийн хаяг, зориулалт бүхий хаяг (PNR-ийн өгөгдөл дамжуулах шаардлагатай улс дахь)
Холбоо барих утасны дугаар	(Утасны дэлгэрэнгүй мэдээлэл)
Цуглуулсан аливаа API-ийн өгөгдөл	Хавсралт I-ийн I параграф буюу хэсэг
Байнга нисэгчийн мэдээлэл	Байнга нисэгчийн дансны мэдээлэл, элит түвшний статус
PNR-ийн код	Файлын дугаар, захиалгын лавлах ба хяналтын дугаар
PNR-д бүртгэгдсэн зорчигчдын тоо	(Тоо)
Зорчигчийн аяллын төлөв буюу статус	Түр горимын буюу хүлээлгэд байгаа мэдээлэл
Огноотой холбоотой бүх мэдээлэл	PNR үүсгэсэн огноо, захиалга өгсөн огноо, урьдчилсан захиалгын огноо, явах огноо, ирэх огноо, PNR-ийн анхны аяллын огноо, PNR-д хамгийн сүүлд өөрчлөлт оруулсан огноо, тийз олгосон огноо, “анх төлөвлөсөн” аяллын огноо, (PNR өгөгдөл дамжуулахыг шаардсан улсад), анх ирсэн огноо, оройтож өгсөн нислэгийн захиалгын огноо
PNR-ийн хуваагдмал мэдээлэл	PNR дээрх хэд хэдэн зорчигч, PNR дээрх бусад зорчигчид, PNR-ийн бусад лавлагаа, захиалга дахь цорын ганц зорчигч



Тийзтэй холбоотой бүх мэдээллийн хэсэг	Тийз олгосон/худалдаж авсан, суудлын ангилал, тийз олгосон хот, тийзийн дугаар, нэг талын нислэгийн тийз, тийз олгосон хот, тийзийн автомат үнийн саналын (ATFQ) хэсэг
PNR дэх аяллын бүх чиглэл буюу маршрут	PNR дэх нислэгийн чиглэлийн хэсэг буюу сегментүүд/боомтууд, чиглэлийн түүх, аялал эхэлсэн хот/суусан цэг, очих хот, идэвхтэй чиглэлийн сегментүүд, цуцлагдсан сегментүүд, түр саатах өдрүүд, ниссэн сегментүүд, нислэгийн мэдээлэл, нислэгийн огноо, суусан цэг, ирэх боомт, нээлттэй сегментүүд, өөр чиглэлийн үл мэдэгдэх (ARNK) сегментүүд, агаарын бус сегментүүд, ирж буй нислэгийн холболтын дэлгэрэнгүй мэдээлэл, хуурай газар дээрх хөдөлгөөний мэдээлэл, баталгаажуулалтын төлөв буюу статус
Төлбөрийн хэлбэрийн талаарх (TX-FOP) мэдээлэл	Бүх TX (бэлэн мөнгө, цахим, зээлийн картын дугаар, хүчинтэй хугацаа, урьдчилсан төлбөрт тийз (PTA), солилцоо), тийзийн үнийг төлж буй хүн/байгууллагын дэлгэрэнгүй мэдээлэл, ажилтнуудын хөнгөлөлтийн код
Бүртгэлтэй холбоотой бүх мэдээлэл	Ерөнхийдөө нислэгийн бүртгэл дууссаны дараа л боломжтой болдог: Бүртгэл баталгаажуулалтын дугаар, бүртгэл хийсэн төлөөлөгчийн үнэмлэхийн дугаар, бүртгэл хийгдсэн цаг, бүртгэлийн төлөв, баталгаажуулалтын төлөв, суудлын дугаар, суудлын үзүүлэлт, бүртгэлийн захиалга
Суудлын тухай бүх мэдээлэл	Урьдчилан захиалсан суудал; нислэг хаагдсаны дараах бодит суудал*1



Ачаа тээшний талаарх бүх мэдээлэл*	Ерөнхийдөө нислэг хаагдсаны дараа нислэгийн хяналтын систем (НХС-DCS)-ээс авах боломжтой: ачаа тээшний тоо, ачаа тээшний шошгын дугаар, ачааны тээшний жин, бүх ачаа тээшний нэгтгэсэн мэдээлэл, нэгтгэлийн толгой хэсэг, нэгтгэлд орсон ачаа тээшний тоо, ачаа тээш тээвэрлэгчийн код, ачаа тээшний төлөв, ачаа тээшийг хүргэх газар/буулгах цэг
Аялал жуулчлалын байгууллагын буюу компанийн талаарх мэдээлэл	Аялал жуулчлалын байгууллагын буюу компанийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нэр, хаяг, холбоо барих хаяг, ОУАТХ-ны код
Хүлээн авсан мэдээлэл	Захиалга өгч буй хүний нэр
Илүү эрт нисэх хүсэлттэй холбоотой мэдээлэл*	Ерөнхийдөө бүртгэл хийгдэж дуусаад, нислэг хаагдсаны дараа л боломжтой: Эрт нисэх хүсэлтийг олж тодорхойлогч
Ирээгүйтэй холбоотой мэдээлэл*	Гагцхүү, нислэг хаагдсаны дараа л боломжтой: Ирээгүйтэй холбоотой түүх
Ерөнхий тайлбар	Ерөнхий тайлбар хэсэг дэх бүх мэдээлэл
Бусад үйлчилгээний тухай мэдээлэл (OSI), тусгай үйлчилгээний хүсэлт (SSR), аюулгүй байдлын талаарх мэдээллийн (SSI) тайлбар/түүх дэх үнэгүй бичвэр буюу текст/кодын хэсэг	ОУАТА-ны бүх код

----o0o----



Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 09-ний өдрийн 174 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**ЗОРЧИГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН
БҮТЭЦ, ОРОН ТОО**

№	Албан тушаал	Орон тоо
Нэг.Удирдлага		
1.1.	Төвийн дарга	1
1.2.	Мэдээлэл хамгаалах ажилтан	1
Хоёр.Захиргаа, хамтын ажиллагааны хэлтэс		
2.1.	Хэлтсийн дарга	1
2.2.	Хууль, эрх зүй хариуцсан ахлах ажилтан	1
2.3.	Хамтын ажиллагаа хариуцсан ахлах ажилтан	1
2.4.	Лавлагаа, мэдээлэл хариуцсан ажилтан	1
2.5.	Зохион байгуулагч (бичиг хэрэг)	1
2.6.	Санхүүгийн ахлах ажилтан	1
2.7.	Санхүүгийн ажилтан	1
2.8.	Туслах ажилтан	2
Гурав.Шуурхай удирдлага, дүн шинжилгээний хэлтэс		
3.1.	Хэлтсийн дарга	1
3.2.	Дүн шинжилгээний ахлах ажилтан	4
3.3.	Дүн шинжилгээний ажилтан	4



Дөрөв.Мэдээллийн аюулгүй байдлын хэлтэс		
4.1.	Хэлтсийн дарга	1
4.2.	Агаарын тээвэрлэгчтэй харилцах ахлах ажилтан	1
4.3.	Мэдээллийн аюулгүй байдлын ахлах ажилтан	1
4.4.	Сан хариуцсан ахлах ажилтан	1
4.5.	Техникийн ажилтан	2
Нийт		26

----oOo----



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.5

Индекс: 200003